



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

САНАА СЭТГЭЛ ХҮЧТЭЙ ЦОЧРОН ДАВЧИДСАН ГЭЖ ҮЗЭХЭД ХОХИРОГЧИЙН ЗҮЙ БУС ҮЙЛДЭЛ, ТУХАЙН ҮЙЛДЭЛ УРЬД ӨМНӨ ДАВТАГДАЖ БАЙСАН ТАЛААРХ ХОХИРОГЧ, ШҮҮГДЭГЧ ХООРОНДЫН ЗАН ХАРИЛЦАА, АМЬДРАЛЫН ХЭВ ШИНЖ, МАРГААНЫ ЭХЛЭЛ, ӨРНӨЛ, ДЭС ДАРААЛЛЫГ ЦОГЦООР ДҮГНЭНЭ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2025/ХШТ/41

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн тогтоолд өөрчлөлт оруулж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгосон.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч Т.Б нь 2023 оны 08-р сарын 31-ний өдрөөс 09-р сарын 01-нд шилжих шөнө СБД-ийн ... хорооны нутаг дэвсгэрт байх орон сууцанд гаднаас согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байдалтай орж ирсэн хохирогч, өөрийн төрсөн хүү болох З.Б-тэй маргалдсаны улмаас түүнийг хутгалж, нийт 23 тооны шарх гэмтэл үүсгэн онц харгис хэрцгийгээр хүнийг алсан гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүхээс:** шүүгдэгч Т.Б-ийг онц харгис хэрцгийгээр хүнийг алсан гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1² дэх заалтад зааснаар 08 жил, 01 сарын хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэсэн байна.
- Давж заалдах шатны шүүхээс:** Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтыг баримталж, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн буюу Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн үндэслэлээр анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.
- Шүүгдэгчийн өмгөөлөгч Б. Дашдорж хяналтын шатны шүүх хуралдаанд хэлсэн саналдаа:** "...Хүн амины хэрэг гарах болсон шалтгаан нөхцөл нь хэрэгт авагдсан баримтуудаас тодорхой харагддаг. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчидсан гэх ойлголтын шинжээчийн дүгнэлтээр тайлбарлах уу, эсхүл хууль

¹Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3730?daterange=2025-01-01%20-%202025-08-19&id=3&court_cat=2&bb=1

² Эрүүгийн хууль(2015)-ийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх хэсэг "Хүнийг онц харгис хэрцгийгээр...алсан бол арван хоёр жилээс хорин таван жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ."



зүйн ойлголтоор тайлбарлах уу гэдэг талаар Улсын дээд шүүх олон тооны тогтоол гаргасан. Шүүгдэгч нь 09 дүгээр сарын 02-ны өдөр яллагдагчаар татагдах үедээ л 23 удаа хутгалсан гэх нөхцөл байдлыг мэдсэн байдаг. Түүний яллагдагчаар өгсөн “эх барих, эмэгтэйчүүдийн эмчээр ажиллаж олон хүүхдэд амьдрал бэлэглэсэн атлаа өөрийнхөө хүүхдийг ийм болгочихлоо” гэх мэдүүлгээс хэргийн үйл баримт тодорхой харагдана. Мөн тэрээр “би хэрэг үйлдэгдэх үед манан шиг цагаан зүйл дунд байсан” гэж мэдүүлснээс үзэхэд, түүнийг сэтгэл санаа хүчтэй цочрон давчидсан байсан гэж үзэх үндэслэлтэй гэж үзэж байна...” гэжээ.

4. **Хяналтын шатны шүүхээс:** Эрүүгийн хуулийн тусгай анги дахь нэг бүлэгт системчлэгдэн хуульчилсан, хуулиар хамгаалагдсан нэг ижил эрх ашигт хохирол, хор уршиг учруулсан гэмт хэргүүдийг ялган зүйлчлэхдээ тухайн гэмт хэргийн онцлог болсон объектив, субъектив шинжийг нь анхааралтай авч үзэж, тэдгээрт бодитой дүгнэлт хийх нь хэргийн жинхэнэ байдалд нийцсэн дүгнэлт хийж, зөв зүйлчлэх үндэс юм. (22)³
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар “гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр”-ийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зайлшгүй нотолсон байхыг үүрэг болгосны ач холбогдол нь хэргийн бодит байдлыг тогтоох, хэргийг зөв зүйлчилж, гэмт этгээдэд шударга ял оногдуулах үндэслэл болдогт оршино. (24)
6. Харин нотлох баримтаар тогтоогдсон хүний амь нас хохирсон хэргийн үйл баримтыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10 дугаар бүлэгт хуульчлагдсан гэмт хэргүүдийн шинжтэй харьцуулан жишиж, зүйлчлэхдээ гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, нөхцөл, шүүгдэгч нь амь хохирогчийг хутгалж, амь насыг нь хохирооход чиглэсэн үйлдлийг хийхэд түлхсэн хүчин зүйлсийг анхаарч үзээгүйн улмаас Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж хяналтын шатны шүүх дүгнэлээ. (26)
7. Ахуйн хүрээнд үйлдэгддэг гэр бүлийн хүчирхийлэл, байнгын шинжтэй хэрүүл маргаан, зөрчил, хүндээр доромжлох, эд хөрөнгийн болон бусад эрхийн хязгаарлалт, аливаа үйлдэл, эс үйлдэл хийлгэхээр албадах зэргээр сэтгэл санааны шаналал, зовлон, стресс зэрэг нь удаан хугацаанд хуримтлагдсанаар өндөр зэргийн тэсрэлт илэрч, гэмт хэрэг үйлдэгдэн гарах шалтгаан, нөхцөл болдог байна. (30)
8. Сэтгэц гэм судлалын шинжлэх ухаанд энэхүү сэтгэцийн үзэгдлийг физиологийн аффект хэмээн тодорхойлдог бөгөөд хүн өөрийнхөө үйлдлийн үр дүнд хор уршиг учрах боломж, аюулын бодит шинжийг ухамсарлах болон түүнийгээ удирдах чадвар буурсан ч сэтгэхүйн байдал бүхэлдээ алдагдаагүй байдаг тул “хэрэг хариуцах чадваргүй” гэж үздэггүй. (31)
9. Шүүгдэгч Т.Б өөрийн төрсөн хүү З.Б-ийн хувийн байдал, амьдралын хэвшил болсон үйлдэл буюу тогтмол согтууруулах ундааны зүйл байнга хэрэглэдэг, энэ үедээ зүй бус үйлдэл гаргадаг талаар “... Талийгаач архи уух болгондоо намайг дарамталж “Танд хамаагүй” гээд түлхдэг, нудардаг, хоёр ч удаа цохиж байсан. ... “Би өөрөө ажил, амьдралаа мэдэж байна, пи*** минь чи намайг хүүхдээ гэж

³ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн шийдвэрийн цогцолборын дугаар болно.

боддог юм уу” гээд бахираад, цус, цэрээ хаашаа ч хамаагүй нийгээд, гэрт сууж байхдаа хүртэл бие засчихдаг. ... нэг уухаараа 10 гаруй хоног үргэлжлүүлэн хэрэглэдэг. Сүүлийн 10 гаруй жил тасралтгүй ууж байна. ...” болон гэж мэдүүлсэн байдаг. Энэ нь хавтаст хэрэгт авагдсан бусад гэрчүүдийн дээрх үйл баримыг гэрчилсэн мэдүүлгүүдээр нотлогддог.(33)

10. Түүнчлэн амь хохирогч Т.Б- нь төрсөн дүүгийнхээ охин, бага насны хүүхэд болох Б.Э-тэй зүй бус харилцаа үүсгэхээр оролдож байсан талаар шүүгдэгчийн мэдүүлсэн нь насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгээр давхар батлагддаг бөгөөд үүнийг үгүйсгэх баримт байхгүй.(37)
11. Хэргийг нягтлан үзэхэд амь хохирогчийн олон жилийн туршид согтууруулах ундааны хамааралтай байснаас гэр бүлийнхнийгээ биеийн болон эд хөрөнгийн хүчирхийлэл, дарамтад оруулж байсан, мөн дүүгийнхээ хүүхэдтэй зүй бус харьцаж байсан нөхцөл байдлын улмаас шүүгдэгч Т.Б нь эх хүний хувьд эмзэглэх, санаа зовних, бухимдал, айдас цөхрөлийн хосолсон байдал бүхий дарамтад орж, **энэхүү дарамт нь цаг хугацаа өнгөрөх тусам хуримтлагдсаар ирсэн байна.**(40)
12. Өөрөөр хэлбэл, Т.Б-ийн санаа сэтгэл хүчтэй цочрон давчдахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь **гэмт хэрэг гарсан цаг хугацаанд бий болсон хохирогчийн зүй бус авираас гадна олон жилийн хугацаанд амь хохирогчоос үүдэлтэй стресс, дарамтад амьдарч ирсэн нөхцөл байдлууд нөлөөлсөн байна.**(42)
13. Мөн шинжээч “хэрэг хариуцах чадвартай” гэж тогтоосон нь санаа сэтгэл нь цочрон давчдаагүй гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд энэ талаарх давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлгүй юм.(48)
14. Зүй бус, ёс суртахуунгүй үйлдэл нь эрх зүйн үр дагаврыг үүсгэх анхдагч нөхцөлийг бүрдүүлсэн эсэхийг зөв тодорхойлохын тулд, ялангуяа ахуйн сэдэлттэй, гэр бүлийн хүрээнд бусдын амь насыг **хохироох болсон шалтгаан нөхцөл нь хохирогчийн зүй бус үйлдэл урьд өмнө нь давтагдаж байсан талаарх хохирогч, шүүгдэгч нарын хоорондын зан харилцаа, амьдралын хэв шинж, харилцааны түүх, маргааны эхлэл, өрнөл, дэс дарааллыг цогцоор нь дүгнэх** нь хуулийн хэм хэмжээний агуулгыг зөв тайлбарлан хэрэглэх боломжийг бүрдүүлдэг.(51)
15. Шүүгдэгч Т.Б-ийн хувьд хүүдээ байнга анхаарал тавьж, асарч тойглодог байсан, архианаас гаргах талаар анхаарч эмчилгээ хийлгэж байсан, өөрөө хүчирхийлэлд өртөж байсан боловч эх хүний хувьд хүүхдэдээ хариуцлага тооцуулах талаар арга хэмжээ авч байгаагүй зэрэг нь анхнаасаа алах санаа зорилго байгаагүй, харин хэрэг үйлдэх үед түүний **амь насыг хохироох гэмт санаа гэнэт үүссэнийг илэрхийлж байна.**(49)
16. Иймд прокуророос шүүгдэгч Т.Б-ийн амь хохирогч З.Б-ийг олон удаа хутгалж, амь насыг нь хохироосон үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг **“санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах”** буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөнгөрүүлэн өөрчлөх нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх дүгнэжээ...”(56)



---o0o---